



XXI зууны малчин

МОДУЛЬ 8 ГАНЦ МОД ГАЛ БОЛДОГГҮЙ...



Хөдөө Аж Ахуйн
Үйлдвэрлэлд Шинжлэх
Ухааны Ололт Нэвтрүүлэх Төв




Олон Улсын Хөдөлмөрийн
Байгууллага

XXI ЗУУНЫ МАЛЧИН

МОДУЛЬ 8. ГАНЦ МОД ГАЛ БОЛДОГҮЙ...





ТАНИХ ТЭМДЭГ



Уншаарай



Анхаараарай



Хамтран ажиллаарай



Хүүхэдтэйгээ ярилцаарай



Өөрийгөө үнэлээрэй



Модуль 8. Ганц мод гал болдоггүй...

Боловсруулсан:

Д.Гүндэгмаа

Хянан тохиолдуулсан:

И.Ханымхан, Ч.Нилбаатар, Н.Монголмаа

Зураач:

Г.Амарсанаа

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн:

Ц.Баяржаргал

АГУУЛГА

1. Удиртгал	4
2. Малчдын бүлэг	9
3. Малчдын хоршоо	20
4. Малчдын бүлэг, хоршооны жишээ, туршлага	25
5. Хавсралт, Малчны бүлгийн дүрэм, дундын сангийн журам ..	33
6. Ашигласан материал	40

МОДУЛЬ 8. ГАНЦ МОД ГАЛ БОЛДОГҮЙ...

Зорилго: Малчдын хамтын ажиллагааг бэхжүүлэх, малчдын бүлэг, хоршооны давуу талыг ойлгох, бүлэг хоршоо байгуулахад оролцох, бүлгээ хөгжүүлж, бэхжүүлэх мэдлэг, чадвар эзэмшин, хамтын ажиллагааны хүрээгээ өргөтгөх хүсэл эрмэлзлэлтэй болно.


Энэхүү модулийг үзэх явцад Та:

- Малчдын бүлэг, хоршоо байгуулах талаар мэдээлэл авах, түүний ач холбогдлыг ойлгох, хамтын ажиллагааны давуу хэлбэрийг сонгох,
- Малчдын бүлэг, хоршоо байгуулахтай холбоотой дүрэм журмыг цуглуулах, туршлага судлах, байгуулах санаачлага гаргах, идэвхитэй оролцох,
- Манлайлагч/ахлагчийн чадавхи, зан төлвийг зөв үнэлэх, зөв сонголт хийх мэдлэг чадвар эзэмших,
- Хамтын ажиллагааны давуу хэлбэрийг сонгон бусадтай хамтран ажиллах, хамт олны өмнө хариуцлага хүлээх, аливаа асуудлыг өөрөө болон бусдын дэмжлэгтэйгээр шийдвэрлэх хандлага, эрмэлзлэлтэй болно.

1. УДИРТГАЛ



Болороо та хоёр овоо “малын дөртэй” болж байна. Танай Болороо айлын талыг аваад явах авхаалжтай, ажилсаг, орсон гарсан хүнд найрсаг сайн охин. Нүднээс далд байна, нэг удаа магтчихъя.



Малчин хүн зөвхөн хар амиа борлуулаад явах биш бусдад туслах, эргээд тэднээс тус дэм авах ухаантай байх ёстой. “Хүн хүнийхээ дэмэнд, загас усныхаа хүчинд” гэж нэг сайхан үг байдаг юм. Санаж явахад илүүдэхгүй.



Зураг 1. Хот айлууд

Малчин хүн хичнээн ажилсаг байлаа ч ганцаараа хийж дийлэхгүй хүчин мөхөсдөх ажил зөндөө байдаг шүү дээ.

Монголчууд бид эртнээс “Айл хүний амь нэг, саахалт хүний санаа нэг” хэмээн хэлэлцэж нэг голынхон, нэг хот айлынхан нэг нэгэндээ тусалж, ажиллаж амьдарч ирсэн уламжлалтай. Хонь хяргах, эсгий хийх, хадлан хадах, малын хашаа хороо барих, отор нүүдэл хийх зэрэг олон хүний хүч шаардах ажлыг хамтран хийж, нэг нэгэндээ тусалсаар ирсэн.

Хот айлынхан хонь малаа нийлүүлэн өдөр өдрөөр ээлжлэн хариулах ба, “хонины хишиг” таарсан айл тэр өдөртөө хот малаа хариуцсан шиг хариуцдаг байлаа.

Айл буух айлыг шилж сонгоход их анхаардаг ба зангаа мэдэхгүй айлтай айлсахаас өмнө асуудаг далд утгатай тусгай асуулт ч байсан юм.

Жишээ нь:

- **Гэр шөргөөдөг тэмээтэй юу?** гэдэг нь өвчтэй, хамуутай мал бий юу?
- **Гэнэт давхидаг нохойтой юу?** гэдэг нь үүдээ сахиад хүн оруулдаггүй, хүнд дасдаггүй нохой бий юу?
- **Хоол бууддаг хүүхэдтэй юу?** гэдэг нь бэлтгэлээ хангахгүй ойр зуурын зүйлийг айлаас гуйдаг уу?
- **Хов зөөдөг чавганцтай юу?** гэдэг нь гэр чагнадаг, эв түнжинг муутгадаг, аливаа асуудлыг дэвэргэн өсгөж хов жив ярьдаг хүн бий юу гэсэн утга санааг тус тус агуулдаг аж.

Айлсах санал тавьсан хүнээс дээрх асуултуудад хариу авсны дараа гэрийн эзэн айл буулгах эсэхийг шийдэн хариу өгдөг. Айл буусан хойноо аль аль нь хичээж, эв түнжинтэй, бие биедээ нөмөр түшигтэй амьдардаг байсан.



Монгол улсын Ерөнхийлөгч агсан, доктор Н.Багабанди

Саахалт айлынхаа хурга ишгийг саах зөрүүлтэл хоньтойгоо бэлчээж, таргалуулан махлуулж, хөршийн төлийг өөрийнх мэт хариулах бичигдээгүй хууль үйлчилж, харилцан хүлээх үүргээ нэн хариуцлагатай ухамсарлан хэрэгжүүлдэг байжээ. Малчид хамтарсны буян их гэдгийг яс махандаа хүртэл ойлгодог хүмүүс. Хэнийтэй хаяа хатган айлсаж, хэнийтэй саахалт буухаа сонгохдоо ус бэлчээрээ бодолцохын зэрэгцээ айл өрхийн гишүүдийн ноён нуруу, ам хэл, ажил үйлийг давхар бодолцдог байв. Айл саахалтын хүүхэд, хөгшидгүй бүгдээрээ ах дүүс мэт ойртон дасаж, жаргал зовлон, баяр хөөр, уйтгар гунигаа хуваалцана. Ахуйн хэрэгцээний дутуу гуцуугаа айл саахалтаасаа залгуулна. Нутаг усандаа нэр хүндтэй, ноён нуруутай, ажилсаг айлтай айл, саахалт буувал аз гийсэн учрал ерөөл. Хаяа муутай айлаас холхон байхыг бодно. Залхуу айлаас зайтай бууна. Хэл амтай хэрүүлч, урт хошуутнуудтай айл буухаас цааргална. Хулгай зэлгий хийдэг, хаяагаа хадардаг буруу гарын хүмүүсээс хол байхыг чухалчилна.

Өнөө үед ч малчдын бүлэг, хоршоог байгуулахдаа санаа нийлсэн айлууд хэнээр ч шахаж шаардуулалгүй нийлж тусгай дүрэм, журмын дагуу дотоод дүрмээ боловсруулан хэлэлцэж баталгаажуулаад, нэгэнт хүлээн зөвшөөрсөн бол гишүүд нь биелүүлдэг ёстой биз дээ?

-За,энэудаамалчдынбүлэг,хоршооны тухай үзнэ. "Буянт" бүлгийн гишүүдтэй уулзаж туршлага судлах даалгавраа хэр зэрэг биелүүлсэн бэ?



-Би мотоциклээр яваад уулзаад үзээд ирсэн. Ёстой гоё юм аа. Зарим нь бэлчээрээ хашиж байна. Зарим нь худгаа засаж байна. Зарим нь гар тэжээл хийж байна. Дундын сангаасаа нэг портер (ачааны жижиг машин) худалдаж авсан байна. Хамаг ажлаа хуваарилж аваад л хийчихдэг гэнэ.



- Худаг засаад байгаа дуулдсан. Ундарга нь сайн гарсан байна уу?
- Давгүй сайн болсон байна
- Олны хүч оломгүй далай гэж тэр дээ. Олон жил ашиглаагүй худаг шүү дээ...





Зураг 2,3. Малчдын бүлгийнхэн худаг засаж байгаа нь



Зураг 4,5. Малчдын бүлгийнхэн бэлчээр хашиж байгаа нь



Зураг 6,7. Малчдын бүлгийнхэн гар тэжээл бэлтгэж байгаа нь





-Гишүүд нь ямар сэтгэгдэлтэй байна даа?

-Ам сайнтай байна. "Буянт"-ын туршлагаар энэ хавьдаа хэдэн санаа нийлсэн айл цуглуулаад бүлэг байгуулах юмсан...



- Санадаг л санаа. Эхлээд энэ номоо үз. Тэгээд сайд бод.



Өөрийгөө үнэлээрэй.

1. Асуултад хариулаарай

№	Асуулт	Мэднэ (тийм/чадна)	Муухан эднэ(чадна)	Үгүй (мэдэхгүй)
1	Малчдын бүлэг, хоршооны талаар мэдэх үү?	★	○	△
2	Малчин Та ямар нэг бүлэг, хоршооны гишүүн мөн үү?	★	○	△
3	Хэрвээ мөн бол Та цаашид гишүүн хэвээр үлдэх үү? Биш бол гишүүнээр элсэх бодол байгаа юу?	★	○	△
4	Хэрвээ Та гишүүн болбол бусдын итгэл найдварыг хүлээх идэвхитэй, хариуцлагатай гишүүн байж чадах уу?	★	○	△
5	Малчны бүлгийн ахлагч ямар хүн байх ёстой вэ?	★	○	△
6	Малчны бүлгийн дундын сан гэж юу вэ?	★	○	△
7	Малчны бүлгийн дундын санг юунд зарцуулдаг вэ?	★	○	△
8	Хоршоо гэж юу вэ?	★	○	△
9	Хоршоог яагаад ардчилсан байгууллага гэдэг вэ?	★	○	△
10	Малчны бүлэг ба хоршооны сайн жишээ, туршлага мэдэх үү?	★	○	△

2. Тухайн дүрсийг хэдэн удаа сонгосноо доод талын дөрвөлжинд тоогоор бичээрэй.

Хэрвээ та ★-г 6 удаа сонгосон бол түүний доод талын дөрвөлжинд **6** гэх мэтээр тэмдэглээрэй.

★	○	△





Санамж



6-8 байвал, Малчны бүлэг, хоршооны талаар туршлагатай, гэхдээ мэдлэг, туршлагаа баяжуулах шаардлагатай байна гэж үзнэ.



4-6 бол Малчны бүлэг, хоршооны мэдлэг, туршлага багатай энэ талаар мэдээлэл авч, сонголтоо хийх шаардлагатай байна.

2-4 байвал, Малчны бүлэг, хоршооны талаар мэдээлэл авч, бусадтай хамтран ажиллахын ач тусыг мэдрэхийг хүсч байна.

2. МАЛЧДЫН БҮЛЭГ



Малчдын бүлэг бол уламжлалт хот айлын өргөжүүлж баталгаажуулсан хэлбэр юм. Малчдын бүлгийг малчид өөрсдөө санаачлан байгуулна. Орон нутгийн удирдлагаас албадах маягаар зохион байгуулбал үр дүн багатай бөгөөд малчид өөрсдөө хүсээгүй учир бүлгийн үйл ажиллагаанд идэвхигүй оролцох ба улмаар тухайн бүлэг сарниж үгүй болдог талтай. Бүлгийн дотоод зохион байгуулалт, бүтэц, гишүүдийн тоо зэргийг хатуу заадаггүй, бүлгийн гишүүд өөрсдөө тогтоодог.

Малчид бүлэг байгуулж хамтран ажиллахын ач холбогдол их юм. Жишээ нь:

- Хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх,
- Байгаль цаг уурын эрсдлийг даван туулах,
- Өрхөөс гарах зардлыг бууруулах гэх мэт.

Малчдын бүлэг байгуулахад дараах асуудлуудыг нэн тэргүүнд шийдвэрлэх хэрэгтэй.

Үүнд:

- Бүлгээр хамтран ажиллах зорилго, үйл ажиллагааны чиглэлээ тодорхойлох,
- Бүлэгт элсэх өрх, хүний тоог тогтоох,
- Бүлгийн ахлагчийг сонгох,
- Бүлгийн дүрэм, дотоод журмыг боловсруулан хэлэлцэж батлах,
- Бүлгийн дундын сангийн асуудлыг хэлэлцэж тохирох,
- Бүлгийн бичиг хэргийг хөтлөх, баримтуудыг бүрдүүлэх

Бүлгийн анхы хурлаар хэрхэн хамтарч ажиллах, ямар дүрэмтэй байх, ахлагч нь хэн байх, бүлэгтээ ямар нэр өгөх зэргийг хэлэлцэнэ.

Хурлыг аль мэдээлэл сайнтай хүн, эсвэл бүлэг байгуулж ажиллах санаачилгыг гаргасан хүн удирдаж, ярилцлага өрнүүлэн, ойлголтын зөрүүг арилгана.



Бүлгийн дүрмийг боловсруулахад хүндрэлтэй байвал орон нутгийн удирдлага болон бусад малчдын бүлгээс тусламж хүсч болно. Бүлгийн дүрэм нь өөрчлөгдөшгүй зүйл биш бөгөөд бүлгийн үйл ажиллагааны явцад шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг тусган боловсронгуй болгох бүрэн боломжтой юм.



Дараа нь бүлгийн Удирдах болон Хяналтын зөвлөл, ахлагчийг сонгоно. Бүлгийн ахлагч ямар хүн байхаас тухайн бүлгийн хувь заяа шийдвэрлэгддэг

Бүлгийн ахлагч нь орон нутагтаа нэр хүндтэй, хүмүүс үгийг нь сонсдог, ажлын дадлага туршлагатай, хариуцлагатай, үнэнч шударга, аливаа асуудлыг бүлгийн гишүүдтэй зөвшилцөж шийдвэрлэдэг, бусдадаа урам зориг, итгэл өгч чаддаг хүн байх ёстой.

Туршлагаас харахад бүлгийн ахлагч нар ихэвчлэн ахмад настай, эрэгтэйчүүд байдаг. Зарим тохиолдолд залуучуудыг ахлагчаар сонгож, туршлагатай ахмад хүнийг бүлгийн зөвлөхөөр томилон ажиллуулж байна. Нутгийн хүмүүс хэн нь хэн бэ гэдгийг сайн мэддэг учир бүлгийн гишүүд ахлагчаа өөрсдөө сонгоно.

Сонгосон ахлагчаа бүлгийн ашиг тусын тулд сургалтад хамруулах, орон нутгийн болон бусад сум аймгийн туршлага судлах боломжоор хангаж чадваржуулна.

Бүлгийн анхны хурлаар дээр дурьдсан асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж, хурлын тэмдэглэл хөтөлж, хуралд оролцсон гишүүд гарын үсгээ зурж баталгаажуулна. Дараа нь сумынхаа Иргэдийн төлөөлөгчдийн хуралд хүсэлтээ гарган бүлгээ албан ёсоор батлуулна.

Бүлгийн зохион байгуулалт буюу ажиллах бүтцийг бүлгийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж баталсан бүлгийн дүрмийн дагуу хийнэ. Малчдын бүлгүүдийн туршлагаас харахад **ахлагч, нарийн бичиг, санхүүч, бусад гишүүд** гэсэн цомхон бүтэцтэйгээр байгуулж байна.



Бүлгийн удирдлага нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:

- Бүх гишүүдийн хурал,
- Удирдах зөвлөл,
- Хяналтын зөвлөл,
- Ахлагч гэсэн бүтэцтэй байх бөгөөд эдгээр талуудын эрх, үүргийг бүлгийн дүрэмд тусгаж баталгаажуулна.

Бүлгийн дундын сан нь бүлгийн гишүүдийн хамтын үйл ажиллагаанд зарцуулагдахаас гадна ган, зуд, гамшгийн үед хэрэглэх нөөц юм.

Дундын санг бүрдүүлж, арвижуулах нь бүлгийн үйл ажиллагааг тогтмол, үр дүнтэй явуулах, бүлгийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх нэг гол хүчин зүйл юм. Дундын сан нь иргэдийн хувийн өмч, хөрөнгөнөөс бүрдэж буй тул зарцуулалтыг гишүүдийн саналаар шийдвэрлэнэ.

Дундын санг бүрдүүлэхдээ гишүүдийн амьжиргааны түвшин, орлого, эрхэлж буй аж ахуй болон олонхийн саналыг харгалзана. Дундын санг шинээр үүсгэн байгуулах, нэмж арвижуулах, өөрчлөн байгуулах, захиран зарцуулах, бүртгэх, хяналт тавих, эрсдэлээс хамгаалахтай холбоотой бүхий л асуудалд гишүүн бүр оролцоно.

Дундын сан дараах эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- Дундын сангийн журам болон бүлгийн анхны хурлаас тогтсон анхны эх үүсвэр болгон нэг гишүүн/гишүүн өрх айлаас оруулахаар тохирсон хөрөнгө,
- Дундын сангаас гишүүдэд олгосон зээлийн хүүгийн орлого,
- Бүлгийн гишүүдээс дундын санд сайн дураараа өгсөн бэлэг, хандив,
- Гадаад, дотоодын байгууллагуудаас өгсөн хандив, тусламжийн хөрөнгө,
- Хамт олноороо хэрэгжүүлсэн үйл ажиллагаанаас олсон орлого ба түүний тодорхой хэсэг,
- Хамт олны хөрөнгө, дэмжлэгээр суралцаж, мэдлэг чадвар эзэмшсэн гишүүний тухайн чадвараа ашиглан явуулсан үйл ажиллагааны орлогоос дундын санд хуваарилсан хөрөнгө,
- Бүлгийн бизнесийн ашгаас дундын санд хуваарилсан хөрөнгө,
- Бүлгийн өмчлөл дэх бусад хөрөнгө гэх мэт

Малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл болон фермерүүд дундын сан байгуулах, улмаар нутгийн иргэдийн санаачилгаар өөрийн санхүүгийн тогтолцоо бий болгох эрх зүйн орчныг бий болгон хөгжүүлнэ. (Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх стратегийн зорилт, 3.1.9.)



Бүлгийн **дундын санг эхлэн бүрдүүлэхийн** тулд гишүүн өрхүүдээс бүрдүүлэх эх үүсвэрийг эхэлж тогтох нь зүйтэй. Бүлэг эхэлж байгуулагдах шатанд малчдын хувьд мал буюу малын гаралтай түүхий эдээр дундын санг эхэлж бүрдүүлэх тохиолдол байдаг. Энэ нь малчдад бэлэн мөнгө хомс байдагтай холбоотой. Туршлагаас харахад малчид дундын санг бүрдүүлэх малаа хэнийд, хаана цуглуулж маллах вэ гэдэг дээр санал зөрөлдөх, дундын санд оруулах малаа тогтсон хугацаандаа нийлүүлэхгүй байх зэргээс дундын сан бүрэн бүрдэхгүй байх явдал гардаг.

Бүлэгт элсэж ажиллах сонирхолтой орлого багатай, малгүй, дундын санд хөрөнгө нийлүүлэх боломжгүй иргэдийн хувьд дундын санд оруулах хувь хэмжээг багаар тогтоох эсвэл хөдөлмөрөөр хувь нийлүүлэх нөхцөлтэйгөөр бүлэгтээ элсүүлж болно.

Дундын сан нь хамт олноороо хэрэгжүүлэх үйл ажиллагааны санхүүжилт болохоос гадна хамт олны итгэлцлийг бэхжүүлэх, гишүүдийн идэвхижүүлэх нэг гол эх сурвалж болдог ач холбогдолтой. Дундын санг бүрдүүлснээр:

- Эрсдэл, гамшиг тохиолдсон үед гишүүдээ хамгаалах нөөц хөрөнгө бүрдүүлэх,
- Хамтарч хийх томоохон ажлын хөрөнгийн эх үүсвэр болох,
- Хамтын бизнес, үйлдвэрлэлээ өргөтгөх, шинэ үйлдвэрлэл, үйлчилгээ нээн ажиллуулахад хөрөнгө оруулалт хийх,
- Бүлгийн орлого багатай гишүүд, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн амьжиргааг тэтгэх, туслах,
- Тулгамдсан аливаа асуудлыг хамтран шийдвэрлэх,
- Сайн ажиллаж буй бүлгийн гишүүдийг шагнаж урамшуулах,
- Баяр ёслол, тэмдэглэлт үйл явдлыг хамтран тэмдэглэх,
- Хамтын үйл ажиллагааны давуу талыг бүлгийн гадна байгаа бусад хүмүүст ойлгуулж, бүлгийн хүрээг өргөтгөх гэх зэрэг олон боломжуудыг нээж өгдөг.

Дундын сангийн төрөл нь бүлгийг үүсгэн байгуулсан зорилго, зохион байгуулалтаас шалтгаалан олон хэлбэртэй байж болно. Үүнд:

- Гишүүдээс нийлүүлсэн мөнгөн хөрөнгө, үүнийг банкинд данс нээлгэж байршуулна.
- Мал
- Малын гаралтай түүхий эд (арьс шир, ноос ноолуур гэх мэт)
- Өвс хадлан, малын тэжээл
- Эм тариа
- Техник, тоног төхөөрөмж (трактор, машин, хадлангийн хэрэгсэл гэх мэт)



- Дундын сангийн хөрөнгөөр бүлгийн үйл ажиллагаа явуулахад зориулж барьсан орон сууц, гэр
- Банкны зээл гэх мэт

Дундын сангийн зарцуулалтыг бүлгийн дүрэм, бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн баталсан дотоод журамд үндэслэн явуулна. **Дундын сангийн хөрөнгийг зарцуулахдаа дараах зарчмыг баримтлана. Үүнд:**

- Дундын сангийн хөрөнгийг бүлгийн болон бүлгийн гишүүдийн эрх ашигт нийцүүлэн зарцуулна.
- Бүлгийн гишүүн дундын санд оруулсан хөрөнгөө дур мэдэн зарцуулах, худалдах, зээлийн барьцаанд тавихыг хориглоно.
- Хийхээр төлөвлөж буй үйл ажиллагаанд зориулж дундын сангаас оруулах хувь хэмжээ нь нийт хөрөнгийн 2/3-оос илүүгүй байна.
- Дундын сангийн өдөр тутмын үйл ажиллагааг бүлгийн ахлагчаас гадна бүлгийн санхүүч удирдан явуулна.
- Дундын сангийн хөрөнгийг бүлгийн гишүүдийн олонхид үр ашиг нь хүртэх үйл ажиллагаанд зарцуулах ёстой.
- Тодорхой ашиг олж, санг арвижуулах үйл ажиллагаанд зарцуулна.
- Бүлгийн аль нэг гишүүнд зайлшгүй тусламж шаардлагатай болсон үед буцалтгүй тусламж эсвэл зээл олгоход зарцуулж болно.
- Сангийн зарцуулалтанд Хяналтын зөвлөл хяналт тавьж ажиллана.

Бүлгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх баримт бичгүүд. Малчдын бүлэг нь өөрөө хуулийн этгээдийн эрхгүй, албан бус байгууллага боловч бүлгийн үйл ажиллагаанд зайлшгүй хэрэглэгдэх дараах дүрэм, журмуудыг боловсруулж мөрдөх нь бүлгийн тогтмол, хэвийн үйл ажиллагааг хангахад ихээхэн чухал үүрэгтэй байдаг.

1. Бүлгийн дүрэм. бол тухайн бүлгийн нийт гишүүдийн үйл ажиллагаандаа баримтлах хамгийн суурь баримт бичиг юм. Бүлгийн дүрмийг бүх гишүүдийн хурлаар баталж, нэмэлт өөрчлөлт оруулна. Бүлгийн дүрмийг тухайн бүлэг өөрсдийн үйл ажиллагааны онцлогт тааруулан янз бүрийн хэлбэрээр хийж болох ч дараах заалтуудыг зайлшгүй оруулсан байх ёстой. Үүнд:

- Бүлгийн нэр, засаг захиргааны харъяалал
- Бүлгийн үйл ажиллагааны чиглэл, зарчим
- Бүлгийн удирдлага, эрх үүрэг, тэдгээрийг сонгох, чөлөөлөх
- Бүлгийн гишүүн, эрх үүрэг, тэдгээрийг элсүүлэх, хасах
- Бүлгийн үйл ажиллагааны санхүүжилтийн хэлбэр
- Бүлгийг өөрчлөн байгуулах болон татан буулгах тухай



Бүлгийн ахлагч хүчин төгөлдөр үйлчилж буй бүлгийн дүрмийг бүлгийн гишүүн тус бүрт хувилж өгөх нь зүйтэй бөгөөд энэ нь нийт гишүүд дүрмийнхээ дагуу өөрсдийн эрх, үүргийг мэдэх, дүрмээ хэрэгжүүлж ажиллахад тустай байх болно.

2. **Бүлгийн бүх гишүүдийн дэлгэрэнгүй бүртгэлийг** бүлгийн ахлагч нарийн бичгийн хамт бүрдүүлэх бөгөөд бүртгэл нь тухайн гишүүн/өрхийн талаарх суурь мэдээллийг өгөх зорилготойгоор хийгддэг. Бүлгийн гишүүдийн бүртгэлийг бүлгийн ахлагч жил бүр шинэчилж байвал зохино.
3. **Бүлгийн дундын сангийн дотоод журам.** ба дундын сангийн хөрөнгийн бүртгэлийг бүлгийн ахлагч нарийн бичиг, санхүүчийн тусламжтайгаар хөтөлнө. Дундын сангийн дотоод журмыг бүлгийн дүрмийн нэгэн адил бүх гишүүдийн хурлаар баталж, хэрэгжилтэнд нь Хяналтын зөвлөл хяналт тавих үүрэгтэй.
4. **Бүлгийн гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөө.** Гамшгаас хамгаалах чиглэлээр нэгдсэн бүлгүүд гамшгаас хамгаалах төлөвлөгөөг зайлшгүй боловсруулж мөрдөх шаардлагатай. Уг төлөвлөгөө нь гамшгийн үеийн зарлал мэдээллийг бүлгийн гишүүн өрхүүдэд хүргэх систем, бүлгийн гамшгийн эмзэг байдлын болон нөөцийн зураглал, бүлгийн гамшгаас хамгаалах хүч хэрэгслийн жагсаалт (гамшигтай тэмцэх хүний болон техникийн нөөц) зэргийг багтаасан байна. Мөн тухайн орон нутагт түгээмэл тохиолддог гамшгийн төрлүүдээр дагнан гамшаас хамгаалах төлөвлөгөөг хийж болдог. Жишээлбэл, ой хээрийн түймрээс хамгаалах төлөвлөгөө, үерийн гамшгийн бэлэн байдлын төлөвлөгөө гэх мэт.
5. **Хурлын тэмдэглэл.** Хурлын тэмдэглэл нь бүлгийн ажил хугацаандаа явагдаж байгааг илтгэх нэг үзүүлэлт болдог. Хурлын тэмдэглэл хөтлөх ажлыг бүлгийн нарийн бичгийн дарга хариуцах бөгөөд хуралд оролцсон гишүүдийн гарын үсгээр баталгаажсан байвал зохино. Тэмдэглэлийг товч, тодорхой хөтөлж, хурлаас гарсан шийдвэрийг тодорхой тусгана. Энэ нь бүлгийн ахлагч гишүүдэд өгсөн үүрэг даалгавраа дүгнэх, ажлын явц байдлыг ярилцах зэрэг олон зүйлд хэрэг болдог.
6. **Бүлгийн жил, улирлын ажлын төлөвлөгөө, тайлан.** Жил, улирлын ажлын төлөвлөгөө, тайлангуудыг нэгтгэн цэгцлэх ажилд бүлгийн ахлагчид нарийн бичгийн даргаас гадна Удирдах зөвлөлийн гишүүд туслалцаа үзүүлж ажиллах ёстой. Эдгээр баримт бичгүүд нь тухайн бүлгийг байгууллагын зохион байгуулалтаар ажиллаж байгаа эсэхийг харуулах хамгийн том шалгуур үзүүлэлт болдог гэдгийг анхаарах нь зүйтэй.
7. **Бүлгийн дундын сангийн мөнгөн хөрөнгийг банкинд байршуулсан дансны дугаар, гарын үсгийн баталгаа.** Дундын сангийн дотоод журамд заасны дагуу бүлгийн ахлагч дундын сангийн мөнгөн хөрөнгийг банкинд байршуулах үүрэгтэй.



Энэхүү банкны данс болон гарын үсгийн баталгаа нь бүлгийн гишүүдийн хувь оролцоо бүхий хөрөнгийг бүлгийн ахлагч дүрмийн дагуу зарцуулж байгаагийн баталгаа болох учиртай.

Бүлгийн ажлын төлөвлөгөөг хийхийн өмнө тухайн бүлгийн хэрэгцээг тодорхойлох нь чухал ач холбогдолтой байдаг. Өөрөөр хэлбэл, тухайн жил хийвэл зохих ажлыг ач холбогдлоор нь дараалуулан бичнэ. Тухайлбал,

- өвлийн бэлтгэл хангах
- бэлчээр хаших
- хадлан бэлтгэх
- худаг засах
- үерийн далан барих гэх мэт.

Дээрх жагсаалтыг гаргахад бүлгийн гишүүн бүрийг оролцуулан нэг буюу хэсэг хүний үзэл бодол давамгайлахаас сэргийлнэ. Тухайн ажил хамгийн чухал гэж хэдэн хүн хүний санал авсан байдлаар нь эрэмбэлнэ.


Өвлийг өнтэй давах болзошгүй зудын хохирлыг бууруулахад чиглэгдсэн ажилд хамгийн түрүүнд анхаараарай. Тухайлбал:

- Малын хашаа хороо барих,
- Хадлан тэжээл бэлтгэх,
- Малаа оторлож таргалуулах,
- Цас малтах, зам харгуй гаргах энгийн багаж хэрэгсэл бэлтгэх,
- Гамшгийн үеийн холбоо, зарлан мэдээллийг сайжруулах гэх мэт

Амьжиргаа дэмжих, ядуурлыг бууруулах чиглэлээр малчдын бүлгүүд маш олон төрлийн ажил санаачилан хийсэн туршлага байдаг. Жишээ нь:

- Хүнсний ногоо тариалах,
- Эсгий хийх,
- Цагаан идээ боловсруулах,
- Блок үйлдвэрлэх жижиг цех нээж ажиллуулах зэргээр орлогоо нэмэгдүүлэх төрөл бүрийн ажлуудыг санаачлан хэрэгжүүлж байна. Энэ нь малчид мал аж ахуйн үйлдвэрлэлийн хажуугаар жижиг үйлдвэрлэл эрхэлж орлого олохын эхлэл болж байна.

Малчин өрх, малчдын бүлэг, хоршоо, нөхөрлөл нь бизнесийн өөр төрлийн үйл ажиллагаанаас орлого олох боломж, нөхцөлийг бүрдүүлнэ. (Төрөөс малчдын талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх стратегийн зорилт, 3.1.4.)



Байгалийн нөөцийг хамгаалахад чиглэгдсэн үйл ажиллагаа. Орон нутгийн иргэдийн амьжиргаа нь тухайн орон нутгийн бэлчээр, ус, ой мод зэрэг байгалийн үндсэн баялгаас ихээхэн хамааралтай байдаг. Энэ чиглэлээр дараах ажлыг төлөвлөн хэрэгжүүлж болох юм. Жишээ нь:

- Бэлчээр хаших,
- Мод тарих,
- Булгийн эхийг хаших,
- Ойг эзэмшилдээ авч цэвэрлэх хамгаалах гэх мэт

Эдгээр ажлууд нь нэг талаас өөрсдийн амьжиргаанд учирч буй эрсдэлийг бууруулах, мал аж ахуйгаа тогтвортой хөгжүүлэх, нөгөө талаас орон нутгийнхаа байгалийн нөөц баялгийг хамгаалж, эзэмших зөв зүйтэй ашиглах боломж, хугацааг нэмэгдүүлж





Дасгал 1. Ганаа, Болороо хоёр малчны бүлэг байгуулах яриагааүргэлжлүүлж дараах зүйлийг хийсэн байна. Та тэдний төлөвлөгөөнд юу нэммээр байна, бодоорой

1. Эхлээд хамтын хүчээр хийх шаардлагатай ажлыг жагсаав. Жагсаалтад их өвөрмөц ажлууд орсон байлаа. Жишээ нь:

- Сайн үүлдрийн хуц, ухна бойжуулж, бүлгийн гишүүн өрхүүдийн хэрэгцээг хангах, зэргэлдээ баг, сумдад борлуулах,
- Цагаан идээ боловсруулах цех байгуулах, сумын төвд үзэсгэлэн-худалдаа гаргах,
- Чөдөр ногт, эмээл хазаар гэх мэт малын тоног төхөөрөмж хийх өрхийн үйлдвэр ажиллуулах,
- Сумаас багш урьж зуны цэцэрлэг ажиллуулах гэх мэт

2. Дээрх ажлуудыг гүйцэтгэхэд санаа нийлэх өрхүүдийг сонгов. Энэ нэлээд амаргүй ажил байсан бөгөөд Ганаа, Болороо хоёр их нухацтай ярилцав. Жишээ нь, зөвхөн мал хөрөнгө нийлүүлэх боломжтой айл элсүүлж болохгүй байлаа. Хөрөнгө мөнгө нийлүүлж чадахгүй ч ажилсаг, зохих хэмжээний боловсролтой хүн ч хэрэгтэй байв. Хөдөө аж ахуйн Их сургуульд суралцаж байгаад ар гэрийн гачигдлаар төгсөж чадаагүй Тулгаа гэдэг залуу сумын төвд байдгийг Ганаа, Болороо хоёр жагсаалтандаа орууллаа.

3. Модулиа цааш нь судлаад өөр шинэ санаа олох, жагсаалтад оруулсан хүмүүсийг урьж санаагаа хэлж, ярилцахаар тохиров. Ганаа “Буянт” малчны бүлгийн туршлагыг, Болороо бүлгийн дүрэм, бүрдүүлэх материалыг танилцуулахаар болов.

Санамж

Хавсралтад буй бүлгийн дүрэм, дундын сангийн журмын загварыг ашиглаарай.






Өөрийгөө үнэлээрэй.

1. Асуултад хариулаарай

№	Асуулт	Мэднэ (чадна)	Муухан мэднэ(чадна)	Үгүй (мэдэхгүй)
1	Малчдын бүлгийн талаар мэддэг болсон уу?	★	○	△
2	Малчдын бүлгийн давуу талыг мэдэх үү?	★	○	△
3	Малчдын бүлгийн талаар бусдад танилцуулж чадах уу?	★	○	△
4	Малчдын бүлгийн жишээ, туршлага мэдэх үү?	★	○	△
5	Малчдын бүлгийг яаж байгуулдгийг мэдэх үү?	★	○	△
6	Малчдын бүлгийн дундын сан ямар зорилготойг мэдэх үү?	★	○	△
7	Малчдын бүлгийн дундын санг яаж бүрдүүлдгийг эдэх үү?	★	○	△
8	Малчдын бүлгийн дүрэмд юу тусгах шаардлагатайг мэдэх үү?	★	○	△

2. Тухайн дүрсийг хэдэн удаа сонгосноо доод талын дөрвөлжинд тоогоор бичээрэй.



Хэрвээ та ★ -г 6 удаа сонгосон бол түүний доод талын дөрвөлжинд **6** гэх мэтээр тэмдэглээрэй.

□ □ □

Санамж



6-8 байвал, Та малчдын бүлгийн талаар мэдээлэлтэй болж байна, гэхдээ өөрөө хийж турших, бодит ажил болгох хэрэгтэй гэж үзнэ.



4-6 бол Та малчдын бүлгийн талаар мэдээлэлтэй болж байна. Гэхдээ өмнө үзсэн хичээлээ үе үе эргэн харж бататгаж байгаарай.



2-4 байвал, малчдын бүлэг, хоршооны талаар шамдан суралцаарай, "Ганц мод гал болдоггүй, ганц хүн болдоггүй" гэдэг үг бий шүү гэж зөвлөж байна.





Хүүхэдтэйгээ ярилцаарай



- Ээж ээ, Бурмаа бид хоёр цэцэрлэгт явах гэж байгаа юм уу?
- Зун болохоор явна аа, миний хүү. Өнгөрсөн жил чи "Гэр цэцэрлэгт" явсан шүү дээ. Гоё байсан уу?
- Гоё байсан. Багш намайг тоо сайн тоолж сураад, олон шүлэг цээжлээд ирээрэй гэсэн.



Хүүхдэддээ цээжлүүлээрэй

Т. Жамьянсүрэн

Тоолж сурлаа

Тав хүртэл
Тоолж сурлаа
Таван хуруугаа
Нэрлэж тоолъё
Эрхий мэргэнийг нэг гэе

Долоовор хуруугаа хоёр гэе
Дунд хуруугаа гурав гэе
Ядам хуруугаа дөрөв гэе
Чигчий хуруугаа тав гэе

Таван хурууг ямар нэртэйг
Та нар цөм мэдэх нь энэ
Тав хүртэл зөв тоолохыг
Дашрамд бас сурах нь тэр
Хуруугаа түргэн дараалж дараад
Хурдан зөв нэрлэж тоолцгоо



3. МАЛЧДЫН ХОРШОО



Хоршоо гэж юу вэ?

Эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээгээ хангах зорилгоор хэд хэдэн этгээд сайн дураараа нэгдсэн, ардчилсан, хамтын удирдлага, хяналт бүхий, дундын эд хөрөнгө дээр үндэслэн үйл ажиллагаа явуулахаар хамтран байгуулсан хуулийн этгээдийг хоршоо гэнэ (Хоршооны тухай Монгол улсын хууль, 3.1.).



Иргэд хамтарч байгуулсан хоршоог **анхан шатны**, хоршоод аж ахуйн үйл ажиллагаагаа хамтран эрхлэх зорилгоор бусад хоршоо болон хуулийн этгээдтэй хамтран **дундын хоршоо** гэдэг.

Анхан шатны хоршоог 9-өөс доошгүй иргэн, дундын хоршоог хоёроос доошгүй хуулийн этгээд байгуулж болно. Хоршоог үүсгэн байгуулах баримт бичиг нь **хоршооны дүрэм** байна. Хоршооны дүрмийг бүх гишүүдийн хурлаар батална. Дүрэмд дараах зүйлийг тусгана. Үүнд:

- Хоршооны оноосон нэр, оршин байгаа газрын хаяг;
- Гишүүдийн овог, нэр, хаяг, үнэмлэхийн болон регистрийн дугаар;
- Хоршооны зорилго, үйл ажиллагааны төрөл;

Хоршоо нь дараах төрлийн үйл ажиллагаа эрхэлж болохыг Хоршооны тухай Монгол улсын хуульд заасан байна. Үүнд:

- 3.4.1. түүхий эд боловсруулалтын;
- 3.4.2. үйлдвэрлэлийн;
- 3.4.3. хадгаламж, зээлийн;
- 3.4.4. борлуулалт, хангамж, бэлтгэн нийлүүлэлтийн;
- 3.4.5. үйлчилгээний;
- 3.4.6. орон сууц барих зориулалтын;
- 3.4.7. эд хэрэглэгчдийн;
- 3.4.8. дүрэмд заасан үйл ажиллагаа.

- Хоршооны үйл ажиллагаа явуулах хугацаа;
- Гишүүнээс хоршоонд оруулах хөрөнгийн доод хэмжээ;
- Гишүүдийн заавал оруулах хувиас гадна хоршоонд нийлүүлж болох хувь хөрөнгийн дээд хэмжээ;
- Гишүүдийн оруулах хувь хөрөнгийг үнэлэх журам;
- Хоршооны орлого, зарлагыг тооцох, бүртгэх, түүнийг хуваарилах журам;



- Хоршооны тайлан;
- Аж ахуйн үйл ажиллагаандаа тухайн хоршооны гишүүн бус этгээдийг оролцуулах нөхцөл, журам;
- Хоршооны гишүүнд элсэх, гишүүнээс гарах, хасах нөхцөл, журам, гишүүний эрх, үүрэг, хариуцлага;
- Гишүүнд үйлчлэх хэлбэр;
- Хоршооны удирдлагын бүрэлдэхүүн, түүний бүрэн эрх, шийдвэр гаргах журам, хүлээх хариуцлага;
- Болзошгүй алдагдлыг нөхөх нөөцийн санг бүрдүүлэх арга, хэлбэр нөөцийн сан, хуримтлуулах жилийн орлогын тодорхой хувь хэмжээ, түүнд байнга байлгах хөрөнгийн доод хэмжээ;
- Хоршооны салбар, төлөөлөгчийн газрын ажиллах үндэслэл, журам, түүний эрх, үүрэг, хариуцлага;
- Хоршооны үйл ажиллагаан дахь дотоодын ба хөндлөнгийн хяналт;
- Хоршоог өөрчлөн байгуулах, татан буулгах үндэслэл;
- Хоршоодын холбоонд эвлэлдэн нэгдэх, түүнээс гарах үндэслэл, журам;
- Бусад зүйл орно.

Хоршооны эд хөрөнгө дараахь эх үүсвэрээс бүрдэнэ. Үүнд:

- Гишүүнээс нийлүүлсэн хувь хөрөнгө;
- Дүрэмд заасан бол гишүүний элсэлтийн татвар;
- Хоршооны үйл ажиллагааны орлогоос хоршооны болзошгүй алдагдлын нөөц санд хуваарилсан хөрөнгө;
- Бэлэглэсэн, хандивласан хөрөнгө;
- Хоршооны өмчлөл дэх бусад хөрөнгө болно.

Бүх гишүүдийн хурлаар **хоршооны дүрмийг** батална. Эцэслэн баталгаажуулсан дүрмийг 2 хувь бэлтгэнэ. Хоршооны нэрийг бусадтай давхардуулалгүй сонгон, дээр дурдсан материалыг үндэслэн Улсын иргэний бүртгэл мэдээллийн газарт бүртгүүлнэ. Үүний дараагаар аймгийн бүртгэл мэдээллийн газраас бөглөсөн “шар” хуудас авч хоршооны данс нээлгэнэ. Дараахь зүйлийг бэлтгэсэн байна. Үүнд:

- Улсын бүртгэлд бүртгүүлэх хураамж 13200 төгрөг
- Хавтасны үнэ 6000 төгрөг
- Баталгаажуулалт хийлгэх 500 төгрөг
- Эхлэлтийн баланс 3 ширхэг гаргуулах тус бүр 600 төгрөг буюу 1800 төгрөг (Энэ балансыг аймгийн тамгын газрын аж ахуйн нэгж хариуцсан мэргэжилтнээс авна)
- Хоршооны хувь нийлүүлсэн хөрөнгийн жагсаалт (Хэрвээ бэлэн мөнгөөр хувь нийлүүлэх бол 500 мянган төгрөгөөс доошгүй байх хэрэгтэй ба дансанд байршуулсан байх ёстой)



- Гишүүдийн нийлүүлсэн хөрөнгө нь мал бол тухайн сумын засаг даргын тодорхойлолтоор баталгаажуулсан байна.
- Хоршооны дарга нь аймгийн иргэний бүртгэл мэдээллийн төвийн өргөдлийн маягтын дагуу гарын үсгээ баталгаажуулна.

Эрдэмтний зөвлөгөө



Ахмад хоршоологч, доктор, профессор Н.Надмид.


Хэрэгцээгээ сайн харах, тэрнээс биш мөнгө олох арга хэрэгсэл мэтээр харж, тухай үед нийлээд салах биш, тогтвортой үйл ажиллагаа явуулж, бэхжих хэрэгтэй. Үүнийг хоршоод сайн анхаарах ёстой.

Жишээ нь хэсэг хонь ямаа үржүүлж байгаа хүмүүс байя гэж бодъё. Бүгдээрээ малаа нийлүүлээд тал дүүрэн малаа бэлчээгээд явах боломж байхгүй, бэлчээр нь ямар байна, нүүдэл суудал хийх боломж нь ямар байна.

Энэ бол худлаа. Харин тал талаасаа ноолуураа нийлүүлээд улсын стандартын дагуу чанартай бэлтгээд хэн хэн хэдийг нийлүүлсэн гэдгээ данс тооцоондоо сайн тэмдэглээд, түүнийгээ 9 айл зэрэг ганзагалаад явах биш 9 өрх нийлээд явбал гарах зардал нь бага харин ч орлого нь нэмэгдэх жишээтэй. Сайн үүлдэрийн хуц, ухна бойжуулах, борлуулах нь маш чухал. Энэ бол яах ч аргагүй малчид хамтарч хийж гүйцэтгэх ажил. Нэг айл нэг хуц, ухна бойжуулаад өөртөө хэрэглээд байвал малын удмын чанар муудаж, цус ойртон, сүрэг мөхөх аюулд ордог. Тиймээс хэд хэдэн айл хамтраад зохион байгуулалттай, зоо техникийн ухааны дагуу нарийн тооцоотой ашиглах ёстой. Ногоо тарихад мөн адил хамтарч хийх, үйл ажиллагаагаа нэгтгэж, өөрийн амьдралын хэрэгцээ болгож хоршоо байгуулах хэрэгтэй гэдгийг анхаарах ёстой.

...Ялангуяа хөдөө орон нутагт таруу, сийрэг байршсан иргэд, малчдад хоршоодын үйлчилгээ маш чухал. Хоршоо сайн хөгжвөл тэд зах зээлтэй болж, амьдрал нь дээшилнэ.

...Ер нь адилхан зорилготой хүмүүс л хоршоо байгуулах хэрэгтэй юм гэж би ойлгодог юм. Жишээ нь нэг багийн хэсэг ногоочид байна гэж бодъё. Тус бүрдээ 0.5 га газартай, ногоогоо тарьдаг, газар нь хоорондоо ойрхон. Гэтэл хэрэглэгдэх тоног төхөөрөмж, тракторыг айл болгон хөлсөлж аваад ажиллуулаад байх шаарлага байхгүй шүү дээ. Харин дундаа нэг иж бүрэн трактортой, тэгээд ээлж дараатай ашиглаад байх, тэрэнд зарцуулагдах шатах тослох материалын зардлыг хэн нь хэдэн га-д авч ажиллуулснаараа



хуваах байдлаар хэндээ ч хохиролгүй байхаар гаргадаг. Иймэрхүү байдлаар дундаа техник аваад хамтарч, хоршиж ажиллаж болно. Эсвэл худаг дээр хамтарч ажиллаж болно. Айл болгон худаг гаргана гэхэд өндөр зардал, дээрээс нь усны ундрага нь ямар ч байх юм билээ. Тэгэхээр боломжтой газар хүмүүс нь нэгдээд дундаа гүний худагтай байх. Тэгээд мөн ээлжилж ашиглаад, зардал мөнгийг нь хэн нь яаж, хэдэн га усалж ашигласнаас хамааран тохируулж тооцоод явчихдаг байхаар хамтарч ажиллаж болно.

...Хоршоо чинь өөрөө үйлдвэрлэл шүү дээ. Хоршооны үйлдвэрлэлийн эзэд нь хоршооны гишүүд, удирдлага нь хамтын удирдлага, хамтын хяналт байдаг.

Тийм учраас нэгэнт л хоршооны гишүүн бол хоршооны үйлдвэрлэлд миний юм гэсэн сэтгэлээс хандах хэрэгтэй. Хоршооны дарга, эсвэл тэргүүлэгчдэд үүрэг болгочихоод хаячихаад байж болохгүй.


...Хоршоо байгуулахын тулд нэгдүгээрт, зорилгоо сайн тодорхойлох, хоёрдугаарт, ижил төстэй зорилготой, хамтарч хоршоо байгуулах хүмүүсээ олох, хоршооны дүрэм, журмыг сайн судалж үзэх, дараа нь бид ямар үр дүнд хүрч чадах вэ гэдэг тооцоо, судалгаагаа сайн хийх зэргээр бодож төлөвлөж чадвал ажил болж, үр ашгаа өгнө шүү дээ. Үүнийг л онцгой анхаарах хэрэгтэй.

Ер нь бол хоршихгүйгээр цаашид явахгүй. Төв суурин газар, том зах зээл дээр борлуулалт хийж байгаа ченжүүд мөнгөжчихлөө. Эдгээрийн ард мөнгөтэй бизнесийн том том хүмүүс байж байна. Ченжүүд орон нутгаар яваад л түүхий эдийг хямд үнээр худалдан авч байна. Дээрээс нь хямд өргөн хэрэглээний бараагаар солих гэх мэтээр давхар ашиг олж ажилладаг. Тухайн үедээ юмыг нь салгаад авчихвал ченжийн хувьд боллоо гэсэн үг.

...Нөгөө талаасаа янз бүрийн эрсдэл, цаг агаарын хүчтэй шороон болон цасан шуурга гэх мэт аюул гамшиг их байна.

Хэрэв бид хоршоотой болоод гэрээ хийчихсэн найдвартай худалдаж авах байгууллагатай ажиллах юм бол байгалийн эрсдэлд орсон ч гэсэн бага алдагдал хүлээнэ.

...Анхан шатны 10 гаруй гишүүнтэй хэд хэдэн хоршоо нэгдэж дундын хоршооны зохион байгуулалтанд орж ажиллах шаардлага ч гарч ирж байна. Мөнгөний гачаалд анхан шатны хоршоод орох нь элбэг байдаг. Мөнгө гэдэг бол тийм ч ороо бусгаа зүйл биш. Өөрөөр хэлбэл, мөнгөө яаж босгож олж ирэх вэ гэдэг олон арга байдаг. Түүнээс мөнгөтэй хүмүүс хоршоо байгуулдаггүй юм. Харин мөнгө муутай, ядруу зүдрүү хүмүүс л хоршоо байгуулдаг. Гэхдээ хоршоог ядуучуудын байгууллага гэж ойлгож болохгүй, хоршоо бол ажилсаг хүмүүсийн, хөдөлмөрлөж чаддаг хүмүүсийн байгууллага шүү дээ. (Хоршооллын мэдээ №02(13)., 2011)





Дасгал 2. Доктор Н.Надмидын зөвлөгөөнөөс хамгийн чухал гэсэн 3 санааг дэвтэртээ бичиж аваарай.

1.

2.

3.



Өөрийгөө үнэлээрэй.

1. Асуултад хариулаарай

№	Асуулт	Мэднэ (тийм/чадна)	Муухан мэднэ(чадна)	Үгүй (мэдэхгүй)
1	Хоршоо гэж юу вэ?	★	○	△
2	Хоршооны төрлийг мэдэх үү?	★	○	△
3	Хоршооны дүрэмд юу тусгадаг вэ?	★	○	△
4	Хоршооны эд хөрөнгө ямар эх үүсвэрээс бүрддэг вэ?	★	○	△
5	Хоршоо яагаад малчдад хэрэгтэй вэ?	★	○	△

2. Тухайн дүрсийг хэдэн удаа сонгосноо доод талын дөрвөлжинд тоогоор бичээрэй.

Хэрвээ та ★-г 6 удаа сонгосон бол түүний доод талын дөрвөлжинд **6** гэх мэтээр тэмдэглээрэй.

★	○	△



Санамж



4-5 байвал, малчны хоршооны талаар амжилттай суралцаж байна, гэхдээ өөрөө хийж турших шаардлагатай байна гэж үзнэ.



2-3 бол малчны хоршооны талаар мэдээлэл авч байна. Гэхдээ өмнө үзсэн хичээлээ үе үе эргэн харж бататгаж байгаарай.



1-2 байвал, өмнөх хичээлээ эргэж сайн уншаад, малчдын хоршооны жишээ, туршлагатай танилцаарай гэж зөвлөж байна.

4. МАЛЧДЫН БҮЛЭГ, ХОРШООНЫ ЖИШЭЭ, ТУРШЛАГА



Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Шарга багийн Улсын тэргүүний “Улиастай” бүлэг 2008 онд байгуулагдсан, нийт 15 өрхийн 62 гишүүнтэй тус бүлэг мал аж ахуй эрхлэхийн зэрэгцээ хоёр га-д төмс, хүнсний ногоо тарьдаг байна.

2011 онд “Орон нутгийн жижиг, дунд үйлдвэрлэлийг дэмжих төсөл”-ийн хүрээнд ОХУ-д үйлдвэрлэсэн, 35 морины хүчин чадалтай иж бүрэн трактор, газар тариалан, мал аж ахуйн тоног төхөөрөмж авчээ. Энэхүү техник, тоног төхөөрөмжийг ашигласнаар арвин ургац авах, хадлан тэжээлээ базаах, эргэлтийн хөрөнгөө нэмэгдүүлэх боломж бүрджээ.

Бэлчээрээ зохистой ашигласан, ажлын байр нэмэгдүүлсэн, жижиг дунд хөгжүүлсэн, малын тоо толгойг бүх төрлөөр өсгөн үржүүлсэн учраас тус бүлэг Өвөрхангай аймгаасаа анх удаа Улсын тэргүүний Малчны бүлгээр шалгарчээ.

Засгийн газрын шагналыг нэг сая 763 мянган төгрөг дагалдсан юм.



Зураг 8. УИХ-ын гишүүн Г.Батхүү “Улиастай” бүлгийнхэнд Улсын тэргүүний малчны бүлгийн батламж, шагналыг гардуулж байгаа нь, 2012 оны 2 сарын 21

Архангай аймгийн “Хутаг өндөр” малчдын бүлэг 2007 онд 5 өрхийн 9 гишүүнтэй байгуулагдан сүү сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэж байна.

2011 онд ХХААХҮЯ-наас зарласан цөцгийн тос боловсруулах жижиг үйлдвэр байгуулах төсөлд хамрагдан 18,0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээл авч, тоног төхөөрөмжөө шинэчилж бүтээгдэхүүний нэр төрлөө олшруулжээ.



Зураг 9. “Хутаг өндөр” малчны бүлгийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн, 2012 оны 5 сарын 15.
Эх сурвалж: <http://www.mongolchamber.mn>

Ховд аймгийн Булган сум, Хэнтий аймгийн Биндэр сумын малчдын бүлгүүд

Малчдын бүлгүүд өөрсдийн дундын сангийн хөрөнгө болон төсөл хөтөлбөрийн санхүүгийн дэмжлэгээр сайн үүлдрийн хуц, ухна худалдан авч сүргийн бүтцийг сайжруулах, мал угаалгын онгоц, малын дулаан өвөлжөө барих зэрэг ажлуудыг мал сүргийг эрсдэлээс хамгаалах ажлын хүрээнд хийдэг.

Мал угаах ажил зохион байгуулалттайгаар хийгдэхээ больсноос малын хамуу, догол, цэцэг зэрэг өвчнөөр өвчлөн тарга хүчээ алдсанаас өвлийн улиралд ихээр хорогдох, арьсны чанар муудсанаас түүхий эд үнэд хүрэхгүй байх зэрэг олон бэрхшээлийг даван туулахаар малчид нэгджээ.

Ховд аймгийн Булган сум, Хэнтий аймгийн Биндэр сумын малчдын бүлгүүд жижиг төслийн санхүүжилтээр барьсан мал угаах онгоцондоо өөрийн бүлгийн гишүүн малчдын малыг хөнгөлттэй үнээр, бусад бүлгийн малчид болон сумын бусад малчдын малыг төлбөртэйгээр угааж, дундын сангийн хөрөнгөө арвижуулж байна. Энэ ажлыг сумын малын эмчийн мэргэжлийн туслалцаатайгаар хийдэн ажээ.





Зураг 10. Ховд аймгийн Булган сумын Баянгол, Хэнтий аймгийн Биндэр сумын Мандалхаан малчдын бүлгийн барьсан мал угаах онгоц 2009-8, 10 сар.
(“Монгол Улсад гамшигийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь” МОН/08/305 төслийн III шатны тайлангаас авав)

Ховд аймгийн Мөнххайрхан сумын малчны бүлгүүд. Ховд аймгийн Мөнххайрхан сумын байгалийн гол нөөц баялаг нь чулуу юм. Тус сумын малчдын бүлгүүдийн гишүүн өрх нэг бүр дулаан хороо, өвс тэжээлийн нөөцтэй болсон байна.



Зураг 11. Ховд аймгийн Мөнххайрхан сумын малчдын бүлгүүдийн барьсан малын дулаан байр, 2007 он. (“Монгол Улсад гамшигийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь” МОН/08/305 төслийн III шатны тайлангаас авав)

Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын “Чулуут”, “Таван-Эрдэнэ” малчдын бүлгүүд жижиг үйлдвэрлэл эрхэлж өрхийн орлогоо нэмэгдүүлэх талаар их туршлага хуримтлуулсан байна. Малчид хүнсний ногоо тарих, эсгий хийх, цагаан идээ боловсруулах, блок үйлдвэрлэх жижиг цех нээж ажиллуулах зэргээр орлогоо нэмэгдүүлэх төрөл бүрийн ажлуудыг санаачлан хэрэгжүүлж байна.





Зураг 12. Хэнтий аймгийн Жаргалтхаан сумын Чулуут малчдын бүлгийн байгуулсан эсгийний үйлдвэр. Ноос сэмлэгч машин, барабан, ноосны агуулах, бэлэн болсон гэрийн эсгий зэрэгтэй Дундговь аймгийн малчдын хамтлагууд танилцаж байгаа нь. 2009 оны 8 сар ("Монгол Улсад гамшгийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь" МОН/08/305 төслийн III шатны тайлангаас авав)



Зураг 13. Таван эрдэнэ малчдын бүлгийн блокны цех.



Зураг 14. Таван эрдэнэ малчдын бүлгийнхэн үйлдвэрлэсэн блокоороо хамтлагийнхаа өрх толгойлсон, 2 хүүхэдтэй эмэгтэйд барьж өгсөн өвлийн байшин.



Говь-Алтай аймгийн Дарив сумын улсын тэргүүний “Баян-Ундрал” хоршооны дарга Балсангийн Авирмэдтэй хийсэн ярилцлагаа



...Өвөг дээдсийн маань үүсгэж, байгуулсан Ундрал нэгдэл маань малаа хувьчилж, тараахаасаа өмнө, мал сүрэг, өмч хөрөнгөө тасдан, үндсэн 3 багийн харьяаллаараа хуваагдсан түүхтэй.

Дараа нь тус тусдаа малаа хувьчилж, хувийн мал бүхий иргэддээ үйлчлэх зуучлах аж ахуйн суурь болгон ахмад үеийнхнийхээ бүтээн байгуулалтын тодорхой хэсгийг авч үлдэж, зах зээлд шилжсэн нь эдүгээ цагийн шинэ маягийн хоршоодын гарааны нөхцөл болсон доо.

Зураг 15. Говь-Алтай аймгийн Дарив сумын улсын тэргүүний “Баян Ундрал” хоршооны дарга Балсангийн Авирмэд


Анхны хурал дээрээ л хийж, хэрэгжүүлэх ажлын зорилго, чиглэлээ гишүүдтэйгээ тохиролцож байсан бодогдоно.

Манай хамт олон энэ хоршоог босгож ирэх гэж халуунд халж, хүйтэнд хөрч явсан, хоршиж хамтрахын давуу тал, жинхэнэ утга чанарыг ойлгуулах гэж их цаг заваа зарцуулсан даа. Хамгийн гол нь гар сэтгэл нийлсэн хүмүүс л аливаа ажлын ноён нурууг босгож ирдэг юм байна лээ.

...Малчид маань ашгаа бусдад заавал илүүчлээд байх хахаж цацсан баян хүмүүс үү гэвэл үгүй. Харин цагаан сэтгэлтэй, гар султай хүмүүс билээ. Манай хоршооны гишүүд, хувийн малынхаа бүхий л ашиг шимийг хоршоо руугаа “зөөдөг” нь өөрсдийн орлогоо нэмэгдүүлж, амьдралаа дээшлүүлэх гэсэн, ашгаа өөртөө авч үлдэх гэсэн итгэл үнэмшил юм даа.

Хоршоо хамгийн ардчилсан байгууллага тул дарга удирдлагууд нь сонгуулийн үр дүнгээр солигдож болно, шилжээд явж ч болно. Харин гишүүд нь хөрөнгийн эзэд нь орон нутагтаа үеийн үедээ ажиллаж амьдарсаар байх тул Буян-Ундрал хоршоо маань тогтвортой оршино.

Манай хоршооны айлууд чинь, хоршоондоо дээд тал нь 5-10 сая, дундаж айл л 3-4 сая төгрөгийн хувь хөрөнгөтэй болчихлоо. Тийм хувь хөрөнгөтэй хүн “За зуд болоо. Нэг машин тэжээл авчирч өг” гэхэд хөрөнгө нь хоршоонд байгаа юм чинь авчирч өгч л таарна. Машин тэжээлтэй малчин хүн дөрвөн мөч тийчилж байсан цагт хотоо харлуулна гэж байхгүй дээ.



Нөгөө хоршихын чинь давуу тал энэ биш үү. Мянган малаа зуданд бараад амиа хорлож байсан гашуун сургамж ойрхон бий шүү дээ. Тэр хүн хойш тавьсан хөрөнгөгүй, зудыг давах бэлтгэлгүй л байж. Манай хоршооны гишүүдийн хувь хөрөнгө нь нэг ёсондоо “үүц” “зудын хуяг” байхгүй юу. Ер нь зуданд нэрвэгдээд, мал нь турж муудаад, үхэж хорогдоод эхэлсэн, өдрөөс өдөрт төлбөрийн чадвараа алдаж байгаа малчдаас “нүүр буруулах” хүн олон болдог нь тэдний ч буруу биш. “Хойтон хавар нь 2 чихийг нь огтолж авалтай биш” гэдэг хэлц үг байдаг шиг тэд чинь бизнес эрхэлж байгаа юм чинь эрсдэлд орохыг хэн хүсэх вэ? Энэ л цагт малчдад өөрсдийнх нь байгууллага хоршоо тусална шүү дээ.

Манай хоршооны оны эхний 2012 оны 9 сарын тайлан гарсан байгаа. Энэ хугацаанд 482 сая төгрөгийн ноос, ноолуур түүхий эд, 366 сая төгрөгийн бараа борлуулалт хийсэн байна лээ. Үйлдвэрлэл, үйлчилгээнээсээ 30 гаруй сая төгрөгийн орлого олсон. Энэ эрчээрээ явбал оны эцэст тэрбум давсан орлого хийгдэх төлөвтэй. Өмнөх жилүүдэд хүрсэн түвшингээсээ нилээдгүй ахина гэсэн дүр зураг л даа.

Сумын төвдөө ногоон бүс, ойн зурвас бий болгох зорилгоор хавар, техникийн хүчээр 2 га атар хагалж, нохойн хаягдал шигдсэн, бохирдол ихтэй довон сондуулыг цэвэрлэж, талбайг хашиж хамгаалахын сацуу усалгааны асуудлыг шийдвэрлэж, 1400 гаруй бургас, улиас, шар хуайс, 1800 ш чацарганы мод тарьлаа.

Манай хамт олон сүүлийн жилүүдэд 30 орчим сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар Сутай худалдааны төв, 20 гаруй сая төгрөгөөр жижиг үйлдвэрийн байр барьж ашиглан, Дарив хээрийн талбайн тохижилт, Усан оргилуур хийж, 480 м/квадрат талбайтай хүлэмжийн тариалалт, ногоо даршлах, талх нарийн боовны, сүү,цагаан идээний, нимгэн төмрийн дархан, гэр ахуйн модон эдлэлийн цех зэргийг буй болгон олон сая төгрөгийн тоног төхөөрөмж суурилуулж, ажлын байр болон орлогоо нэмэгдүүлж байгаагийн зэрэгцээ худалдааны төвд өөртөө үйлчлэх тасаг, кассын систем зэрэг орчин үеийн үйлчилгээний соёлыг нэвтрүүлэхэд анхаарч ирлээ.

Эдгээр бүтээн байгуулалт, хөрөнгө оруулалт, орчин үеийн үйлчилгээ нь хоршиж хамтрахын давуу тал нь сум, орон нутгийнхаа хөгжилд түлхэц, дэм болж байгаагийн эхлэл, үлгэр дууриал юм даа. Өөрөөр хэлбэл Дарив сумын уугуул суугуул иргэдийн сайн сайхан амьдралын төлөө л зориулагдаж байгаа юм шүү дээ.



Дасгал 3. Говь-Алтай аймгийн Дарив сумын улсын тэргүүний “Баян-Ундрал” хоршооны дарга Балсангийн Авирмэдтэй хийсэн ярилцлагаас тодруулсан хэсгийг дахин уншаад хоршооны ач холбогдлын талаар ярилцаарай.



-Сурсан зүйлээ
хэр зэрэг хэрэгжүүлж
байгааг чинь энэ
удаа арай өөрөөр
үнэлнэ. Малчны
бүлэг байгуулах
анхны хурал
зохион байгуулах
төлөвлөгөө гаргаад
ирээрэй

-За тэгье.



**Адиа Ганаад хурдан морины цол цээжлээд, морь цоллож байгаарай
хэмээн зөвлөв. Ганаа ч дуртай зөвшөөрөв**

Хурдан морины цол

Бүрэн эрхт Монгол улсын ... аймаг . . . сумын ард. . .ний

Удамт азарганы үр
Уургын гүүний унагаа
Хамаг олны дурыг татсан
Ханашгүй цэнгэлийн манлай
Уулын цаанаас уралдаад ирдэг
Улам холоос дэгдээд ирдэг

Төмөр зуузай сунган гүйдэг
Түмэн агтнаас түрүүлж гүйдэг
Мяндсан жолоо сунган гүйдэг
Мянган агтнаас түрүүлж гүйдэг
Заан дөрвөн соёог яралзуулаад
Заамал зургаан хүзүүгээ гүдэлзүүлээд
Төө сайхан чихээ солбилзуулаад
Төгрөг хар нүдээ тормолзуулаад



Туулай сайхан зоогоо хотолзуулаад
Тураг сайхан биеэ товолзуулаад
Өтгөн сайхан сүүлээ сагсалзуулаад
Өнгөт сайхан дэлээ намилзуулаад
Эрчимт дөрвөн туурайгаа жирэлзүүлээд
Эрдэнэт дөрвөн хөлөө гялалзуулаад
Дайрч ирсэн даян хүлэг
Давхиж гарсан хангайн буга
Даяар гайхамшигт
Даамай хурдан
Ган зуузай
Галт идэр хүлэг ээ
Энэ наадмын өмнө
Эрхэм цолыг өргөн дэлгэрүүлсэн
Ирэх наадмын өмнө
Эх цолыг тэмдэглүүлсэн
Олон түмэн ардын өмнө
Онц сайхан үзэмж болсон
Төрдөө чимэг
Түмэндээ алдар
Эзнээ баярлуулсан
Ижлээ аривжуулсан
Магтаж баршгүй эрдэнэт
Мандуулж баршгүй үзэсгэлэнт
Элдэв зүйлийн
Эрдэнэсийн шинж бүрдсэн
Энх амгалан
Эрх жаргалант
Тод магнай
Торгон жолоо
Түмэн эх ээ



“СУТАЙ” МАЛЧНЫ БҮЛГИЙН ДОТООД ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1 Малчдын бүлэг нь Монгол улсын үндсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжууд болон энэхүү дүрмийн хүрээнд үйл ажиллагаа явуулах малчдын үүсгэн санаачилсан байгууллага юм. (цаашид бүлэг гэх). Бүлэг нь 9-өөс дээш гишүүн өрхтэй (цаашид гишүүд гэх) байна.
- 1.2 Бүлэг нь 2013 оны 03 сарын 1-ний өдрөөс эхлэн нутаг дэвсгэртээ бэлчээрийн усан хангамжийг сайжруулах, бэлчээрийг зохистой ашиглах, сайжруулах, хамтын ажиллагаанд тулгуурлан орлогоо нэмэгдүүлж, гишүүдийхээ амьжиргааг сайжруулах зорилгоор дүрмээ баталсан бөгөөд энэ өдрийг тус бүлэг үүсгэн байгуулагдсан өдөрт тооцно.
- 1.3 Бүлгийн оноосон нэр “Сутай” малчдын бүлэг гэнэ.
- 1.4 Малчдын бүлэг нь орон нутгийн захиргаа болон олон улсын хөтөлбөр төсөл болон гишүүдтэйгээ хамтран зорилгодоо тодорхойлсон чиглэлээр үйл ажиллагаа явуулах бөгөөд бүлэг нь Монгол улсын Ховд аймгийн Дарив сумын Буянт багийн Дэлгэр нэртэй газарт байрлана.
- 1.5 Бүлгийн гишүүд үр дүнтэй хамтран ажиллах, бүлгээ бэхжүүлэхийн тулд бүлгийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулан, бүлгийн нэр дээр дундын сан байгуулж банкинд харилцах данстай болно.

ХОЁР. Эрхэм зорилго

- 2.1 Байгаль орчинд ээлтэй тогтвортой үйлдвэрлэл эрхлэн бүс нутгийнхаа хөгжил дэвшилд тэргүүлэх үүрэг гүйцэтгэдэг баян чинээлэг гишүүд бүхий хүчирхэг бүлэг болно.

ГУРАВ. Зорилт

- 3.1 Бүлгийн нутаг дэвсгэр дэх бэлчээр, усны нөөцийг зөв зохистой урт хугацаанд тогтвортой ашиглах, хамгаалах, сайжруулах замаар байгалийн нөөцийн үнэлэмжийг нэмэгдүүлэх талаар гишүүдийнхээ үүсгэл санаачилгыг хэрэгжүүлэх,
- 3.2 Мал аж ахуйн үйлдвэрлэлд нэмүү өртөг бий болгох, мал аж ахуйн бус орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэх замаар гишүүдийхээ амьжиргааг дээшлүүлэх.

Хэрэгжүүлэх арга зам

- 3.3 Бүлгийн дотоодын нөөц, гишүүдийн идэвхи санаачлага, оролцоо, хүчин чармайлт нь эрхэм зорилгод хүргэх гол арга зам юм.



- 3.4 Ижил зорилго, чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, дотоод, гадаадын хуулийн этгээд, хөтөлбөр, төсөлтэй хамтран ажиллана.
- 3.5 Бүлгийн хөгжлийн урт хугацааны төлөвлөгөө, дунд хугацааны бизнесийн төлөвлөгөөтэй байна.

ДӨРӨВ. Бүлгийн бүтэц зохион байгуулалт

- 4.1 Бүлгийн эрх барих байгууллага нь бүх гишүүдийн хурал байна. Бүх гишүүдийн хурлыг сар бүрийн 25-нд тогтмол хийнэ.
- 4.2 Бүлэг нь удирдах зөвлөлтэй байх ба удирдах зөвлөл нь бүлгийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулна.
- 4.3 Бүлгийн үйл ажиллагааг бүлгийн бүх гишүүдийн хурлаар сонгогдсон ахлагч эрхлэн гүйцэтгэнэ.
- 4.4 Бүх гишүүдийн хурлаар нууцаар санал хурааж сонгосон бүлгийн ахлагч нь бүлгийг удирдана. Бүлгийн ахлагчийн бүрэн эрхийн хугацаа гурван жил байна.
- 4.5 Ахлагч нь удирдах зөвлөлийн дарга байх ба дараах эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- а. Бүлгийн хурлыг зарлан хуралдуулах, хуралдааныг даргалах
 - б. Бүлгийг гадаад, дотоодод төлөөлөх, бүлгийн нэрийн өмнөөс төр засгийн болон гадаад дотоодын байгууллага аж ахуйн нэгж, иргэдтэй харьцаж бүлгийн хурлын шийдвэрийн дагуу гэрээ хэлцэл байгуулах

ТАВ. Бүлгийн удирдах зөвлөл

- 5.1 Удирдах зөвлөл нь 3 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд бүлгийн ахлагч нь удирдах зөвлөлийн бүрэлдэхүүнд багтана.
- 5.2 Удирдах зөвлөл нь сард нэгээс доошгүй удаа хуралдана.
- 5.3 Удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа хоёр жил байна.
- 5.4 Удирдах зөвлөлийн хурлыг гишүүдийн 100-с доошгүй хувийн ирцтэй тохиолдолд хүчинтэйд тооцох ба асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ.
- 5.5 Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
- а. Бүлгийн жилийн төсөв, тайланг хэлэлцэх
 - б. Бүлгийн жилийн ба улирлын ажлын төлөвлөгөө, удирдах зөвлөлийн гишүүдийн хариуцах ажил үүргийн хуваарь, чиглэл төсөв зардлын хэмжээг тогтоох,
 - в. Бүлгийн дүрэм, бусад хууль тогтоомж болон хамтын шийдвэрийг зөрчсөн удирдах зөвлөлийн гишүүнийг түдгэлзүүлэх, нөхөн сонгох.



ЗУРГАА. Хяналтын зөвлөл

- 6.1 Бүлэг, түүний үйл ажиллаганд хяналт тавих үүрэг, зорилго бүхий 3 хүний бүрэлдэхүүнтэй хяналтын зөвлөл байна.
- 6.2 Хяналтын зөвлөлийн бүрэн эрхийн хугацаа нэг жил байна.
- 6.3 Хяналтын зөвлөлийн гишүүд нь дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. Үүнд:
 - а. Удирдах зөвлөлийн хуралд шийдвэр гаргах эрхгүйгээр ажиглагчаар оролцох,
 - б. Бүлгийн үйл ажиллагаанд хяналт тавих,
 - в. Бүлгийн дундын сангийн санхүүгийн үйл ажилагаанд хагас жилд 1-ээс доошгүй удаа шалгалт хийж, үр дүнгийн тайланг удирдах зөвлөл болон бүх гишүүдийн хуралд тайлагнах.

ДОЛОО. Гишүүнчлэл

- 7.1 Бүлгийн эрхэм зорилго, бүлгийн дүрэм үйл ажиллагааг дэмжиж хамтран ажиллах хүсэл сонирхол бүхий малчин өрх бүлгийн гишүүн байж болно. Ийнхүү гишүүнээр элсэх хүсэл сонирхол бүхий иргэд, өрх өөрсдийн сайн дурын үндсэн дээр гишүүн болох хүсэлтээ гарган түүнийг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн баталж гишүүнээр элсүүлнэ.
- 7.2 Гишүүд нь энэхүү дүрэм болон бүлгийн бүх гишүүдийн хурлаар хэлэлцэж баталсан асуудал, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд идэвхи санаачилгатай оролцох үүрэгтэй.
- 7.3 Шинээр элссэн гишүүд нь энэхүү дүрэм ба бүлгийн хамт олны дундын сангийн журмыг дагаж мөрдөнө.
- 7.4 Гишүүн сайн дураараа гишүүнчлэлээс татгалзаж болно. Гишүүнчлэлээс гарах болсон шалтгаанаа удирдах зөвлөлд бичгээр гарган өгч шийдвэрлүүлэн, бүлгийн гишүүдийн бүртгэлээс нэрээ хасуулна.
- 7.5 Гишүүнээс гарсан тохилдолд бүлгийн дундын санд оруулсан хандивийг анх оруулсан хэмжээгээр буцааж олгоно.

НАЙМ. Бүлгийн эд хөрөнгө, санхүүжилт

- 8.1 Бүлэг нь дүрэмд заасан үүрэг зорилтоо хэрэгжүүлэх үүднээс эргэлтийн хөрөнгө, дундын сантай байна.
- 8.2 Дундын сангийн журам нь бүлгийн дүрмийн салшгүй хэсэг байх бөгөөд сангийн бүрдэл, зарцуулалт, хяналтын асуудлыг тус журамд заасны дагуу мөрдлөг болгоно.



- 8.3 Бүлгийн санхүүгийн эх үүсвэр нь бүлгийн гишүүн өрх, байгууллагын хандив, аж ахуйн үйл ажиллагааны орлого болон бусад эх үүсвэр байж болно.

Ес. Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах

- 9.1 Бүлгийн үйл ажиллагааг явуулахад дүрэмтэй холбогдон гарч буй бэрхшээлийг арилгах, үйл ажиллагааны чиглэлд өөрчлөлт оруулах шаардлага гарсан болон бүлгийн зорилго бүрэн хэрэгжсэн тохиолдолд дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах асуудлыг бүх гишүүдийн хурлаар хэлэлцэн, гишүүдийн 70-аас дээш хувийн саналаар шийдвэрлэнэ.

АРАВ. Бүлгийг өөрчлөн байгуулах ба татан буулгах

- 10.1 Бүлгийн зорилго, стратегийн зорилтууд биелэх, нийгмийн хөгжил цаг үеийн шаардлагаар зорилгоо шинэчлэн өөрчлөлт оруулах шаардлага гарсан үед бүлгийг өөрчлөн байгуулж болно.
- 10.2 Бүлэг нь зорилго, зорилтоо бүрэн биелүүлсэн, эсвэл зорилго, зорилтоо биелүүлэх санхүүгийн болон бусад боломжгүй болох тохиолдолд татан буугдана.
- 10.3 Бүлэг татан буугдах тохиолдолд түүний хөрөнгийг тухайн үед байгаа бүх гишүүдэд анх оруулсан хандивийн хэмжээгээр хуваан олгох ба хэрэв аль нэг төсөл хөтөлбөртэй хамтран ажиллаж, тэдгээрийн дэмжлэг санхүүжилтээр тоног төхөөрөмж, эд материалыг түр эзэмших, ашиглах, түрээслэж байсан бол бүрэн хэмжээгээр буцаан төлнө /буцааж өгнө/. Хэрэв бүлэг нь тэдгээр тоног төхөөрөмж, эд материалыг дахин ашиглах боломжгүй болсон зэрэг шалтгаанаар бүрэн хэмжээгээр буцаан өгөх боломжгүй бол бүлгийн дундын сангаас төлбөрийг гаргана. Бүлгийн дундын сангийн хэмжээ хүрэлцэхгүй бол бүлгийн гишүүн бүр хувь тэнцүүлэн төлбөрийг хувааж төлнө.



Бүлгийн ахлагчийн гарын үсэг: Овог, нэр/гарын үсэг.....

Бүлгийн бүх гишүүдийн гарын үсэг:

1. Овог, нэр/ гарын үсэг.....
2. Овог, нэр/ гарын үсэг.....
3. Овог, нэр/ гарын үсэг.....
4. Овог, нэр/ гарын үсэг.....
5. Овог, нэр/ гарын үсэг.....
6. Овог, нэр/ гарын үсэг.....
7. Овог, нэр/ гарын үсэг.....
8. Овог, нэр/ гарын үсэг.....
9. Овог, нэр/ гарын үсэг.....
10. Овог, нэр/ гарын үсэг.....



“СУТАЙ” МАЛЧНЫ БҮЛГИЙН ДУНДЫН САНГИЙН ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү бүлгийн дундын сангийн журам нь Ховд аймгийн Дарив сумын “Сутай” малчны бүлгийн дүрмийн салшгүй хэсэг болно.
- 1.2 Бүлэг байгуулагдсан өдрөөс эхлэн дундын сангийн журмын дагуу банкинд данс нээлгэн, хамтарсан хяналтын дагуу зарцуулж, бүлгийн бүх гишүүдэд тайлагнана.
- 1.3 Бүлгийн гишүүн бүр бүлгийн хурлаар тогтоосон ижил хэмжээний мөнгөн дүн болох 10'000 төгрөгийг бүлгийн нэр дээр нээлгэсэн Хаан банкны 503035226 тоот дансанд сар бүрийн 25-ны дотор хийж, мөнгөний баримтыг бүлгийн ахлагчид хүлээлгэн өгнө.
- 1.4 Шаардлагатай зарим тохиолдолд дундын санд хийх хуримтлалын хэмжээ ба хугацааны өөрчлөлтийг бүлгийн нэгдсэн хурлаар хэлэлцэн баталгаажуулна

ХОЁР. Дундын сангийн бүрдэл

Бүлгийн дундын санг дараах гурван үндсэн зорилгоор бүрдүүлнэ.

2.1. Эргэлтийн сан бүрдүүлэх хуримтлал

Зорилго:	Эргэлтийн сан бүрдүүлэх
Зориулалт	Гишүүдэд буцалтгүй тусламж, зээл, гачигдал
Хугацаа	Сар бүр
Нэг гишүүн өрхөөс нийлүүлэх хэмжээ	• Сар бүр 5000 төгрөг • Бүх гишүүд жилд 2 удаа малын гаралтай түүхий эд борлуулсан орлогоосоо тус бүр 50'000 төгрөгийг дундын санд тушаана. • Бүлэг нийтээрээ хэрэгжүүлсэн орлого нэмэгдүүлэх төрлийн үйл ажиллагаанаас олсон орлогын 30 хүртэлх хувийг дундын эргэлтийн санд тушааж хуримтлал үүсгэнэ.



2.2. Ус цэгийн байгууламжийн 10%-ийн зардлын хуримтлал

Зориулалт	Уст цэг байгуулах зардлын 10% (оролцооны хувь гэх) болох 5 сая төгрөгийг 3 шатлалтайгаар бүрдүүлж дансанд тушаана.
Хуримтлал гүйцээх хугацаа	Нэгдүгээр шат: Малчны бүлэг нь уст цэгийн тендер зарлагдахын өмнө 500.000 төгрөгийг, Хоёрдугаар шат: Худгийн өрөмдлөгийн ажил эхлэхийн өмнө 500.000 төгрөгийг, Гуравдугаар шат: Худгийн барилгын ажил эхлэхээс өмнө үлдсэн хэсгийг гэрээт байгууллагын дансанд тус тус байршуулах
Нэг гишүүн өрхөөс нийлүүлэх хэмжээ	Бүлгийн гишүүн өрх бүр 50 000 төгрөг, 50000 төгрөг, 30000 төгрөг гэсэн шатлалтайгаар тухай бүр дансанд байршуулах

2.3. Бизнес төслийн санхүүжилтын 10%-ийн зардлын хуримтлал

Зориулалт	Бүлгийн бизнес төслийн хөрөнгө оруулалтанд зориулан бүлгээс санхүүжүүлэх 10%-ийн зардлыг бүрдүүлэх
Хуримтлал гүйцээх хугацаа	Бизнес төсөл батлагдан хөрөнгө оруулалт авахын өмнө
Нэг гишүүн өрхөөс нийлүүлэх хэмжээ	Бүлгийн гишүүн өрхийн тоо, төслийн санхүүжилтийн дүнгээс хамаарч тухай үед нь тогтооно.

ГУРАВ. Дундын сангийн зарцуулалт

- 1.1 Бүлгийн бүх гишүүдэд ашиг хүртээх үйл ажиллагаа, орлого нэмэгдүүлэх, уст цэг байгуулах, ашиглах, засварлах ба бэлчээр хамгаалах, сайжруулах үйл ажиллагаанд зарцуулна.
- 1.2 Бүлгийн аль нэг гишүүний гачигдал, хамт олны тэмдэглэлт үйл явдалд зориулан мөнгөн тусламж үзүүлэх хэмжээг тухайн үед нь бүлгийн гишүүдийн шийвэрээр тогтооно.
- 1.3 Бүлгийн гишүүн өрхүүдэд зориулан дундын сангийн нийт дүнгийн 50%-иас хэтрэхгүй, богино хугацаатай, бага хүүтэй зээл олгож болно.
- 1.4 Бүлгийн дундын санг нийт гишүүдийн хурлын шийдвэрийг үндэслэн зарцуулна.



ДӨРӨВ. Дундын санд тавих хяналт

- 1.1 Бүлгийн ахлагч нь удирдах зөвлөлийн гишүүний хамт сангийн хөрөнгө, зарцуулалтанд хяналт тавина.
- 1.2 Бүх зарцуулалтын анхан шатны баримтыг хөтлөн тайланг хагас ба бүтэн жилээр бүх гишүүдийн хуралд танилцуулна.
- 1.3 Дундын сангийн санхүүгийн бүртгэлийг журмын дагуу хөтлөнө.

ТАВ. Бусад

Бүлгийн дундын сангийн бүртгэлийг доорх хүснэгтийн дагуу хөтөлнө.

д/д	Сар өдөр	Гүйлгээний утга	Гүйлгээний дүн			Гарын үсэг
			Орлого	Зарлага	Үлдэгдэл	
1						
2						
3						
4						
5						



Бүлгийн ахлагчийн гарын үсэг: Овог, нэр/гарын үсэг.....

Бүлгийн бүх гишүүдийн гарын үсэг:

1. Овог, нэр/ гарын үсэг.....
2. Овог, нэр/ гарын үсэг.....
3. Овог, нэр/ гарын үсэг.....
4. Овог, нэр/ гарын үсэг.....
5. Овог, нэр/ гарын үсэг.....
6. Овог, нэр/ гарын үсэг.....
7. Овог, нэр/ гарын үсэг.....
8. Овог, нэр/ гарын үсэг.....
9. Овог, нэр/ гарын үсэг.....
10. Овог, нэр/ гарын үсэг.....



АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. Багабанди Н., Титэм үг, УБ., 2012
2. Байгалмаа П., Нутгийн иргэдэд түшиглэсэн гамшгийн эрсдэлийн менежмент, ("Монгол Улсад гамшгийн аюулыг бууруулах менежментийн тогтолцоог боловсронгуй болгох нь" МОН/08/305 төсөл III шатны тайлан) УБ., 2010
3. Хоршооны тухай Монгол улсын хууль, 2002
4. Хоршооллын мэдээ №02(13)., 2011
5. <http://www.egov.mn>
6. <http://www.mongolia.coop>



ХӨДӨӨ АЖ АХУЙН
ҮЙЛДВЭРЛЭЛД
ШИНЖЛЭХ
УХААНЫ ОЛОЛТ
НЭВТРҮҮЛЭХ ТӨВ

Монгол Улс
Улаанбаатар хот-15141
Чингэлтэй дүүрэг #60/1 байр
Утас/факс: 976 70118087
Вэб сайт: <http://www.naec.mn>
И-мэйл: info@naec.mn

ОЛОН УЛСЫН
ХӨДӨЛМӨРИЙН
БАЙГУУЛЛАГА

НҮБ-ын байр, Өрөө 209
Нэгдсэн үндэстний гудамж
Сүхбаатар дүүрэг
Улаанбаатар 14201,
Монгол Улс
Утас: 976 11 320624
Факс: 976 11 320625
<http://www.ilo.org>
